



СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/1142

Улаанбаатар хот

Аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн төрийн үйлчилгээний жишиг албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг Засгийн газрын 2019 оны “Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай” 276 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт батлах тухай нийтлэг журам”, Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 32 дугаар тушаал, Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн “Үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” 05 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн Нягтлан бодогчийн албан тушаалын тодорхойлолтыг 1 дүгээр, Хэмжүүр баталгаажуулалтын техникчийн албан тушаалын тодорхойлолтыг 2 дугаар, Лабораторийн эрхлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 3 дугаар, Лабораторийн шинжээч-дээж хүлээн авагч /химич, нян судлал, хорио цээр/-ийн албан тушаалын тодорхойлолтыг 4 дүгээр, Сорьц тогтоох лабораторийн үнэт металл хайлагчийн албан тушаалын тодорхойлолтыг 5 дугаар, лаборант /шил угаагч/-ийн албан тушаалын тодорхойлолтыг 6 дугаар, Няравын албан тушаалын тодорхойлолтыг 7 дугаар, Гэрээт-жолоочийн албан тушаалын тодорхойлолтыг 8 дугаар, гэрээт-үйлчлэгчийн албан тушаалын тодорхойлолтыг 9 дүгээр хавсралт ёсоор тус тус шинэчлэн баталсугай.

2. Хэлтсийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан батлагдсан жишиг албан тушаалын тодорхойлолтод зарим чиг үүргийг нэмэгдүүлэн баталж, мөрдүүлэхийг Аймаг дахь Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Стандарт, хэмжил зүйн даргын 2020 оны 73 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.УУГАНБАЯР



132209725